



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэрэх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2025/158/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: З.Ундармаа Утас: 8901-1289 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Ахлах аудитор/Аудитор: Т.Золбоо Утас: 9111-1254 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Аудитор: Б.Батчимэг
---	---

1. Хараат бус аудиторын дүгнэлт



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2025.02.24 № 1-6/86

тантай _____ -ны № _____ -т

ДЭЛГЭРЭХ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ЭНХСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэрэх сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 0.5 сая төгрөгийг интернетийн төлбөрт, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 0.05 сая төгрөгийг интернетийн төлбөрт, 0.3 сая төгрөгийг стандартын ном худалдан авах зардалд нийт 0.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын 14 албан хаагчид ээлжийн амралттай байх хугацаанд нийт 2.0 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Бусад асуудал

Дэлгэрэх сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын 27 арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллажээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

442502010

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,171,298.27	161,144,045.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	61,730,339.60	88,157,284.56
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	61,730,339.60	88,157,284.56
3121	Төгрөг	61,730,339.60	88,157,284.56
31211	Төрийн сангийн харилцах	61,730,339.60	88,157,284.56
33	АВЛАГА	2,075,899.77	2,075,899.77
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,072,899.77	2,072,899.77
335	Бусад авлага	3,000.00	3,000.00
3351	Байгууллагаас авах авлага	3,000.00	3,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	72,365,058.90	70,910,860.90
351	Түүхий эд материал	14,572,123.00	14,021,875.00
35110	Тусгай зориулалттай материал	13,886,923.00	13,336,675.00
35130	Эм боох материал	685,200.00	685,200.00
354	Хангамжийн материал	57,792,935.90	56,888,985.90
35410	Бичиг хэргийн материал	4,067,306.00	5,556,906.00
35420	Аж ахуйн материал	46,888,629.90	44,226,179.90
35460	Хүнсний материал	6,535,100.00	6,804,000.00
35470	Бусад хангамжийн материал	301,900.00	301,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	539,332,921.63	680,513,463.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	539,332,921.63	680,513,463.36
392	Биет хөрөнгө	533,159,588.15	674,029,196.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	541,998,071.00	691,114,826.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(53,571,966.90)	(67,013,874.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	53,440,165.00	49,849,060.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,165,624.44)	(28,876,033.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,736,041.80	13,580,890.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,316,041.67)	(2,859,999.87)
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,630,118.00	29,201,350.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(21,119,436.23)	(13,495,282.78)
39217	Ном	2,528,261.59	2,528,261.59
393	Биет бус хөрөнгө	6,173,333.48	6,484,266.66
39301	Программ хангамж	752,000.00	352,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(722,666.52)	(11,733.34)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,144,000.00	6,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	675,504,219.90	841,657,508.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,421,609.00	377,167.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,421,609.00	377,167.00
413	Өглөг	1,421,609.00	377,167.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	421,689.00	226,967.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	170,720.00	-
4136	Бусад өглөг	829,200.00	150,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	829,200.00	150,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	674,082,610.90	841,280,341.59
51	Засгийн газрын хувь оролцоо	674,082,610.90	841,280,341.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,064,547.30	38,064,547.30
51101	Өмч: - төрийн	38,064,547.30	38,064,547.30
512	Хуримтлагдсан үр дүн	636,018,063.60	803,215,794.29
51210	Өмнөх үеийн үр дүн	636,018,063.60	636,018,063.60
51220	Тайлант үеийн үр дүн	-	167,197,730.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	675,504,219.90	841,657,508.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	387,840,960.06	686,895,882.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	173,285,515.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	173,285,515.00
120009	Бусад орлого	-	2,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		171,285,515.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,840,960.06	513,610,367.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	358,976,000.00	480,563,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	358,976,000.00	480,563,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,864,960.06	33,047,067.42
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,864,960.06	33,047,067.42
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	352,486,365.46	511,738,569.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	352,486,365.46	511,738,569.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,486,365.46	511,738,569.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,825,590.02	354,707,286.04
210101	Үндсэн цалин	178,597,850.48	260,468,457.82
210102	Нэмэгдэл	46,753,967.54	91,544,467.22
210104	Урамшуулал	8,473,772.00	2,694,361.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,188,352.00	43,704,517.00
210201	Тэтгэврийн даатгал	22,978,598.00	30,623,754.00
210202	Тэтгэмжийн даатгал	877,600.00	3,278,752.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	702,100.00	1,639,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	175,700.00	1,000,154.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,454,354.00	7,162,457.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,988,240.06	29,937,347.42
210301	Гэрэл, цахилгаан	2,877,050.06	2,853,312.42
210302	Түлш, халаалт	25,834,750.00	24,810,555.00
210303	Цэвэр, бохир ус	1,276,440.00	2,273,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,583,200.00	14,540,430.00
210401	Бичиг хэрэг	1,560,600.00	3,034,300.00
210402	Тээвэр, шатахуун	-	2,288,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	54,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,022,600.00	9,163,150.00
2105	Нормативт зардал	25,513,460.00	34,695,650.00
210502	Хоол, хүнс	25,233,110.00	34,695,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	3,210,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	3,210,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	280,000.00
210702	Дотоод албан томилолт	-	280,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	2,737,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,046,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	576,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,000.00	1,115,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,667,523.38	27,925,638.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,595,530.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	630,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,071,993.38	25,295,638.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	35,354,594.60	175,157,313.36
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	7,959,582.67
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө		4,809,334.67
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал		3,150,248.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(7,959,582.67)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	35,354,594.60	167,197,730.69

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>387,840,960.06</u>	<u>515,610,367.42</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,000,000.00
120009	Бусад орлого	-	2,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,840,960.06	513,610,367.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	358,976,000.00	480,563,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	358,976,000.00	480,563,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	28,864,960.06	33,047,067.42
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,864,960.06	33,047,067.42
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>326,743,062.28</u>	<u>489,183,422.46</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,743,062.28	489,183,422.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,743,062.28	489,183,422.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,902,818.22	354,707,800.04
210101	Үндсэн цалин	178,675,078.68	260,468,971.82
210102	Нэмэгдэл	46,753,967.54	91,544,467.22
210104	Урамшуулал	8,473,772.00	2,694,361.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,994,144.00	43,898,725.00
210201	Тэтгэврийн даатгал	21,243,690.00	30,817,962.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,258,800.00	3,278,752.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,007,100.00	1,639,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	252,900.00	1,000,154.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,231,654.00	7,162,457.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,564,960.06	30,108,067.42
210301	Гэрэл, цахилгаан	2,807,797.06	2,853,312.42
210302	Түлш, халаалт	24,582,190.00	24,810,555.00
210303	Цэвэр, бохир ус	1,174,973.00	2,444,200.00
2105	Нормативт зардал	25,018,550.00	34,964,550.00
210502	Хоол, хүнс	25,018,550.00	34,964,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	2,939,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	2,939,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	1,115,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	420,000.00	1,115,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,542,590.00	21,450,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,807,040.00	17,354,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,735,550.00	4,095,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>61,097,897.78</u>	<u>26,426,944.96</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	61,097,897.78	26,426,944.96
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		61,730,339.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	61,730,339.60	88,157,284.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	38,064,547.30	-	636,018,063.60	674,082,610.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,064,547.30	-	636,018,063.60	674,082,610.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,064,547.30	-	636,018,063.60	674,082,610.90
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	38,064,547.30	-	636,018,063.60	674,082,610.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,064,547.30	-	636,018,063.60	674,082,610.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	167,197,730.69	167,197,730.69
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,064,547.30	-	803,215,794.29	841,280,341.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	575,314,900.00	489,183,422.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,314,900.00	489,183,422.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575,314,900.00	489,183,422.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,044,600.00	354,707,800.04
210101	Үндсэн цалин	302,492,500.00	260,468,971.82
210102	Нэмэгдэл	120,294,900.00	91,544,467.22
210104	Урамшуулал	2,257,200.00	2,694,361.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,583,800.00	43,898,725.00
210201	Тэтгэврийн даатгал	33,717,900.00	30,817,962.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,965,800.00	3,278,752.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,983,300.00	1,639,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,983,300.00	1,000,154.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,933,500.00	7,162,457.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,370,600.00	30,108,067.42
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.00	2,853,312.42
210302	Түлш, халаалт	24,810,600.00	24,810,555.00
210303	Цэвэр, бохир ус	4,560,000.00	2,444,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Норматив зардал	39,411,800.00	34,964,550.00
210502	Хоол, хүнс	39,411,800.00	34,964,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	2,939,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	2,939,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,591,800.00	1,115,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,591,800.00	1,115,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,312,300.00	21,450,280.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,191,100.00	17,354,380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,121,200.00	4,095,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	575,314,900.00	515,610,367.42
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,000,000.00
120009	Бусад орлого	-	2,000,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	540,277,300.00	480,563,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	540,277,300.00	480,563,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,037,600.00	33,047,067.42
132001	Орон нутгийн төсвөөс	35,037,600.00	33,047,067.42
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		61,730,339.60
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		88,157,284.56
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	15.00	15.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	7.00	7.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 18.1 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 15.2 сая төгрөгийн 2 алдааг залруулж, залруулагдаагүй 2.9 сая төгрөгийн 4 зөрчилд, 2.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 0.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, үнийн дүнгүй 2 зөвлөмжийг хүргүүлэв.

3.1. Аудитын явцад залруулсан алдаа:

1. Орлого, үр дүнгийн тайланд зардлын ангиллыг нийт 13.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.

2. Сумын ИТХ-ын шийдвэрээр акталсан 2 хөрөнгийг зарлагадахдаа хуримтлагдсан элэгдлийн данс буруу сонгосон байна.

3.2. Төлбөрийн акт

1. Байгууллагын 14 албан хаагчид ээлжийн амралттай байх хугацаанд нийт 2.0 сая төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

3.3. Албан шаардлага

Тайлант онд мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлаас 0.5 сая төгрөгийг интернетийн төлбөрт, хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 0.05 сая төгрөгийг интернетийн төлбөрт, 0.3 сая төгрөгийг стандартын ном худалдан авах зардалд нийт 0.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

3.4. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. *Илрүүлэлт:* Мэдээлэл оруулах хэрэглэгчийн эрхийг тохируулаагүйн улмаас хүүхдийн хоолны материал худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тайлан, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг огт байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-т “..., төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7-т “цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт”, 8.4.8-т “..., төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байнга ил тод, нээлттэй байлгана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, цаашид хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

2. Цалингийн бүртгэлтэй холбоотой асуудал

2.1. *Илрүүлэлт:* Тайлант оны ерөнхий журналд 67.0 сая төгрөгийн нийгмийн даатгал, ХХОАТ болон үйлдвэрчний эвлэлийн өглөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн

байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2023 оны А/229 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3 дугаар бүлгийн 3.5-т заасан “Ажилтны цалин хөлс, олговрыг дараах байдлаар бүртгэнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгссөн зөвлөмж: Монгол Улсын Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 3 дугаар бүлгийн 3.5 дахь хэсгийн дагуу цалингийн зардлыг нягтлан бодох бүртгэлд тусгах

Дээрх 2 зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн хөдөлгөөний буруу хуримтлагдсан элэгдлийн дансанд бүртгэсэн	1	1,849.2			1	1,849.2	1	1,849.2				
Орлого, үр дүнгийн тайлангийн НББ-ийн алдаа	1	13,378.4			1	13,378.4	1	13,378.4				
Дүн	2	15,227.6			2	15,227.6	2	15,227.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
							Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	2,035.5	1	2,035.5	-	-	-	-	-	-
Төсвийн зориулалт бус зарцуулалт	1	860.2	-	-	1	860.2	-	-	-	-
Цалингийн зардлын дансны бичилт	1	-	-	-	-	-	1	-	-	-
Дүн	3	2,895.7	1	2,035.5	1	860.2	1	-	-	-

